



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 4.5 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Уран зургийн галерейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 18,057,500.00 (арван найман сая тавин долоон мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 14,295,534.00 (арван дөрвөн сая хоёр зуун ерэн таван мянга таван зуун гучин дөрвөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Монголын Уран зургийн галерейн захирал Б.Сарантуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу тухайн байгууллагын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000607



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дүгээр сарын 26-ны өдрийн
36 / дугаар тогтоолын хавсралт

УРАН ЗУРГИЙН ГАЛЛЕРЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАХ АВТОМАШИН

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Тоёота Ланд крузейр прадо 2056 УБЗ суудлын, арал KZJ950093325	2007/2015	169439	18,057,500.00	14,295,534.00	3,761,966.00	-	3,500,000.00
				18,057,500.00	14,295,534.00	3,761,966.00		3,500,000.00
	Нийт дүн			(арван найман сая тавин долоон мянга таван зуу)	(арван дөрвөн сая хоёр зуун ерэн таван мянга таван зуун гучин дөрөв)	(гурван сая долоон зуун жаран нэгэн мянга есөн зуун жаран зургаа)		(гурван сая таван зуу)